

БИЕТ АЛТНЫ ФОРВАРД АРИЛЖААНЫ ГЭРЭЭ

2024 оны 03 дугаар сарын 14 өдөр
хот

№

Улаанбаатар

Энэхүү Биет алтны дараа төлбөрийн нөхцөлтэй гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г
Нэг талаас [REDACTED]

[REDACTED] ХХК (цаашид
“Банк” гэх),

нөгөө талаас Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайвны өргөн чөлөө, Блю ский тауэр 7-р давхар хаягт орших Бороогоулд ХХК (РД: 2094533) (цаашид “харилцагч” гэх) (хамтад нь “талууд” гэх) дараах нөхцлүүдийг харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Гэрээний ерөнхий зүйл

1.1. Энэхүү гэрээний зорилго нь Харилцагч гэрээгээр тохирсон нөхцөлөөр Банканд биет алт худалдах, Банк худалдан авсан биет алтны үнийг гэрээнд заасан ханшаар худалдагчид төлөхтэй холбогдон үүсэх талуудын үүргийн гүйцэтгэлийн биелэлтийг баталгаажуулах болон тэдгээртэй холбогдон үүсэх бусад харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэ гэрээнд өөрөөр заагаагүй бол Банк нь Харилцагчаас зөвхөн үнэт металлын сорьц тогтоох итгэмжлэгдсэн лабораториор тогтоогдсон сорьц бүхий гулдмай хэлбэртэй биет алтыг худалдан авах ба гэрээнд заагдсан худалдагчийн дансанд алтны төлбөрийг шилжүүлнэ.

1.3. Энэхүү гэрээнд харилцагчаас худалдан авах алтны хэмжээ болон ханшийг “унц” нэгжээр хэмжих бөгөөд 1 унц нь 31.1034768 граммтай тэнцэнэ.

1.4. Банк биет алт худалдан авах тохиолдол бүрт гулмай алтны тоо ширхэг, алт, мөнгөний бохир жин, цэвэр жин, алт, мөнгөний үнэ, нийт хэлцлийн дүн, суутган төлүүлэх татвар болон бусад төлбөрийн дүн, худалдагчийн төлбөр хүлээн авах данс зэрэг мэдээллийг агуулсан “Алтны арилжааны хэлцэл”-ийг энэхүү гэрээний хавсралтийн дагуу худалдагчтай тусад нь хийнэ. Талуудын хооронд хийгдсэн “Алтны арилжааны хэлцэл” нь энэхүү гэрээний салшгүй нэгэн хэсэг болно.

1.5. Харилцагч энэхүү гэрээний хүрээнд алт тушаахаас ажлын нэг хоногийн өмнө банкинд урьдчилсан байдлаар тушаах алтны хэмжээг мэдэгдэнэ.

1.6. Банк ажлын өдрийн 09.00 цагаас 18.00 цагийн хооронд алт хүлээн авч, хэлцлийг хийнэ.

Хоёр. Арилжааны нөхцөл

2.1. Арилжааны нөхцлийг дараах байдлаар тохиролцов. Үүнд:

2.1.1. Форвард арилжаа хийгдэх хугацаа: 2024 оны 3 дугаар сарын 14-ны өдрөөс 2024 оны 12-р сарын 31-ний өдрийг хүртэл

2.1.2. Худалдах алтны нийт хэмжээ: 50,000 унц

2.1.3. Арилжааны ханш: 1 унц = 2,000.00 ам.доллар

2.1.4. Төлбөр тооцооны хэлбэр: бэлэн бус

2.1.5. Харилцагчийн төлбөр хүлээн авах данс: [REDACTED]

- 2.2. Гэрээний хугацаанд Арилжааны нөхцөл өөрчлөгдөхгүй.
- 2.3. Банк нь гэрээ байгуулагдсан өдрөөс хойших харилцагчийн Алтны арилжааны хэлцлээр худалдсан алтны цэвэр жингээр энэхүү гэрээний 2.1.2-т заасан худалдах алтны хэмжээг бууруулна.
- 2.4. Харилцагч сар бүр хамгийн багадаа 4,500 унц алтыг банкинд тушаах бөгөөд тухайн сардаа тус хэмжээнд хүрээгүй тохиолдолд дараагийн сард багтаан нөхөж тушаана.
- 2.5. Гэрээний 2.4 дэхь заалт 2024 оны 3 дугаар сарын тушаалтад хамааралгүй болно.
- 2.6. Хэрэв сүүлийн 2 сарын байдлаар 2.4-д заасан хэмжээтэй алтыг банкинд тушаагаагүй тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээс хугацаа хэтэрсэн хоног тутамд 0.1 хувийн алдангийг банкинд төлнө.
- 2.7. Гэрээний 2.5-д заасан алдангийн тооцохдоо өмнөх өдрийн Лондонгийн металлын биржийн хаалтын ханшийг мөрдлөг болгоно.

Гурав. Банкны эрх, үүрэг

3.1. Банк дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

- 3.1.1. Биет алтыг Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төвөөр баталгаажуулсан жингээр жигнэж авах, хүлээн авсан тухай актын нэг хувийг худалдагчид өгөх;
- 3.1.2. Худалдагч сорьц тогтоолгосон алтан гулдмайгаа худалдах хүсэлт гаргасан тухай бүр энэхүү гэрээний 1.4-т заасны дагуу Алтны арилжааны хэлцэл хийх, хэлцлийг тус гэрээний 2.1.3-т заасан ханшаар тооцон харилцагчид төлөх;
- 3.1.3. Худалдаж авсан алтны үнийн дүнг тухайн үеийн Монголбанкны алт худалдан авах ханшаар тооцон нөөцийн төлбөр, татварыг суутган авч худалдагчийн нэрийн өмнөөс Сангийн яамны улсын төвлөрсөн төсвийн орлогын дансанд шилжүүлэх;
- 3.1.5. Худалдан авсан алт, мөнгөний үнийн дүнгээс нөөцийн төлбөр, татвар, урьдчилгаа зээл, зээлийн хүү зэрэг суутган төлүүлэх төлбөрүүдийг хасч, үлдсэн дүнг худалдагчийн энэ гэрээний 2.1.5-т заасан дансанд шилжүүлэх;
- 3.1.6. Худалдагчийн тушаасан алтан гулдмайг 3 сар хүртэл хугацаанд ямар нэг шимтгэлгүйгээр хадгалах.

3.2. Банк дараах эрх эдэлнэ. Үүнд:

- 3.2.1. Энэ гэрээнд өөрөөр заагаагүй тохиолдолд зөвхөн Улсын сорьцын хяналтын албанаас сорьц тогтоосон, гулдмай хэлбэртэй биет алтыг худалдаж авах;
- 3.2.2. Алтны үнийг гэрээний 2.1.3-т заасан ханшаар худалдан авах;
- 3.2.3. Мөнгө худалдан авах үнийг тухайн үеийн Монголбанкны ханшаар тооцон авах;
- 3.2.3. Гурван сараас дээш хугацаагаар хадгалсан алтыг дахин жигнэх замаар холбогдох тооцоо хийх;
- 3.2.4. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг худалдагчаас шаардах.

Дөрөв. Худалдагчийн эрх, үүрэг

4.1. Худалдагч дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

- 4.1.1. Худалдах алтыг банкны алт мөнгөн тэмдэгт хариуцсан ажилтанд жигнүүлж, хүлээлгэн өгөх;
- 4.1.2. Худалдах алтанд Улсын сорьцын хяналтын албаар сорьц тогтоолгон, сорьцын нэг хувийг банкны дилерт өгч, хэлцэл хийх;



4.1.3. Тухайн хэлцлийн алт, мөнгөний үнийн дүнг энэхүү гэрээний 2.1.5 дахь хэсэгт зааснаас өөр дансанд шилжүүлэх бол албан ёсоор банкинд хүсэлт гаргах замаар мэдэгдэх;

4.1.4. Худалдагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч солигдсон тохиолдолд шинэ итгэмжлэгдсэн төлөөлөгчийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг (овог нэр, албан тушаал, гарын үсгийн баталгаа гэх мэт) агуулсан албан хүсэлт өгөх;

4.1.5. Худалдагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь банкинд алт тушаах болон алтны арилжааны хэлцэл хийхдээ иргэний үнэмлэх, түүнтэй адилтгах бичиг баримтаа авч ирсэн байх.

4.1.6. Гэрээний 2.1.1-т заасан хугацаанд 2.1.2-т заасан хэмжээгээр, 2.1.3-т заасан үнээр банкинд алт худалдах.

4.1.7. Хэрэв харилцагч 4.1.6-д заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд банкинд учирсан аливаа хохирлыг барагдуулна.

4.1.8. Хууль болон гэрээнд заасан бусад үүрэг.

4.2. Худалдагч дараах эрх эдэлнэ. Үүнд:

4.2.1. Алтны арилжааны хэлцэл байгуулах, хэлцэлд заасан хугацаанд алтны төлбөрийг банкнаас шаардан авах;

4.2.2. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг банкнаас шаардах.

Тав. Алтны үнийг шилжүүлэх

5.1. Банк алт, мөнгөний нийт үнийн дүнгээс нөөцийн төлбөрийг болон бусад зөвшөөрөгдсөн төлбөрийг хассан үнийн дүнг Банкн дахь харилцагчийн [REDACTED] тоот төгрөгийн дансанд хэлцэлд заасан өдрөөс хэтрэлгүйгээр шилжүүлж байна.

Зургаа. Баталгаа, хариуцлага

6.1. Худалдагч нь олборлосон алтны гарал үүслийг банкинд үнэн зөв мэдэгдсэн болно.

6.2. Банк нь харилцагчийн төлбөр тооцоог хэлцэл хийсэн даруйд хурдан шуурхай гүйцэтгэх ба банк хоорондын гүйлгээг Монголбанкны систем ажиллах хугацаа хүртэл гүйцэтгэнэ.

Долоо. Гэрээний хугацаа

7.1. Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болох ба 1 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна.

7.2. Худалдагч гэрээний 2.1.2-д заасан хэмжээ бүхий алтыг банканд худалдсан тохиолдолд уг гэрээг дуусгавар болсонд тооцно.

Найм. Бусад зүйл

8.1. Энэхүү гэрээтэй холбогдон гарч болох аливаа маргааныг талууд харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд тохиролцоонд хүрэхгүй тохиолдолд Монгол Улсын шүүхээр маргаанаа шийдвэрлүүлнэ.

8.2. Энэ гэрээг 2 хувь үйлдэж, хоёр тал тус бүр нэг хувийг хадгалсан нь хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

8.3. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр нэмэлт гэрээ байгуулах замаар




гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

8.4. Талууд гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэх, дамжуулах, худалдахыг хориглоно.

Гэрээ байгуулсан:

Банкийг төлөөлж:



A handwritten signature in black ink, written over a horizontal line.

Худалдагчийг төлөөлж:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Д.ЦЭРЭНБАДАМ



“Биет алтны форвард арилжааны гэрээ”-ний хавсралт

АЛТНЫ АРИЛЖААНЫ ХЭЛЦЭЛ

20... оны дугаар
хот
сарын - ний өдөр

№

Улаанбаатар

1.1.	Худалдан авагч:	
1.2.	Худалдагч:	“.....” ХХК
1.3.	Алтны худалдан авах үнэ:	1 унц = 2,000.0 ам.доллар
1.4.	Мөнгөний ОУБХЗ-ын үнэ:	1 унц = ам.доллар
1.5.	Монголбанкны ханш:	1USD=.....MNT
1.6.	Алтны тооцоо:	

	№	Слидка	Бохир жин	Сорьц	Цэвэр жин	Үнэ	Нийт төлбөр	Нөөцийн төлбөр	Олгох дүн
1									
	Нийт								

1.7. Мөнгөний тооцоо:

	№	Слидка	Бохир жин	Сорьц	Цэвэр жин	Үнэ	Нийт орлого	Нөөцийн төлбөр	Олгох дүн
1									
	Нийт								

- 1.8. Нөөцийн төлбөрийн хувь:
1.9. Өсөн нэмэгдэх татварын хувь:
1.10. Урьдчилгаа зээл, хүү:
1.11. Төлбөр хийх банк, данс:
1.12. Лицензийн дугаар, харьяа:
1.13. Валют арилжаа:
1.14. Нөөцийн төлбөр

1.15	Төбөр хийх огноо:
------	-------------------

ХУДАЛДАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:



ХУДАЛДАН АВАГЧИЙГ
ТӨЛӨӨЛЖ:

